



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ-3” ТӨХК-ИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АУДИТЫН КОД: САГ-2019/109/СТА-ТӨХК

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.



Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор **Ц.Наранчимэг**
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер **Я.Самбууням**
Утас: 261885 Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn
Ахлах аудитор **Л.Хонгорзул**
Утас: 260512 Цахим хаяг: khongorzull@audit.gov.mn
Аудитор **Б.Даваабаатар**
Утас: 260512 Цахим хаяг: davaabaatarb@audit.gov.mn

Үндэсний аудитын газар



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Дулааны цахилгаан станц-3” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2018/109/СТА-ТӨХК

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2019 он

Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг

Утас: 261663

Аудитын менежер: Я.Самбууням

Утас: 261685

Аудитор:

Утас: 260512

Цахим хаяг: Naranchimegts@audit.gov.mn

Цахим хаяг: Sambuunyamy@audit.gov.mn

Б.Даваабаатар

Цахим хаяг: davaabaatarb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
НББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	4
2	Аудитын тайлан.....	6
	2.1. Оршил.....	6
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	6
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	7
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	7
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	8
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	9
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	9
	2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	10
	2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл.....	10
	2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.....	10
	2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	13
	2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	13
	2.11. Шилэн дансны мэдээлэл.....	14
	2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	14
	2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	14
3	Менежментийн захидал.....	15
	3.1 Зардлын данстай холбоотой асуудал.....	
	3.1.1 Илрүүлэлт.....	15
	3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар.....	16
	3.2.1 Илрүүлэлт.....	16
	3.2.2 Эрсдэл.....	16
	3.2.3 Өгсөн зөвлөмж.....	16
	3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар.....	16
	3.3 Зорилтот түвшингийн хэрэгжилттэй холбоотой асуудал.....	16
	3.3.1 Илрүүлэлт.....	16
	3.3.2 Эрсдэл.....	17

3.3.3 Өгсөн зөвлөмж.....	17
3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар	
4 Аудит хийсэн санхүүгийн тайлан	18
4.4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан.....	19
4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан.....	20
4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан	21
4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан.....	22



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тогтоо 9, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37 | Факс: 62-26-32 30
E-mail: info@audit.gov.mn

"ДУЛААНЫ ЦАХИЛГААНЫ СТАНЦ-3"
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ч.ЧИНБАТ ТАНАА

2019.03.15 № 06/461
тэнэй _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Дулааны цахилгаан станц-3" ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол "Дулааны цахилгаан станц-3" ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар "Дулааны цахилгаан станц-3" ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



Аудитын гол асуудал

Шагнал урамшуулалд тооцоололгүй, шалгуур үзүүлэлтгүй 509.0 сая төгрөгийг хавтгайруулан олгосон, орон сууцны дэмжлэг үзүүлэх зардалд 2,418.0 сая төгрөгийг төлсөн боловч гүйцэтгэгч компани барилга барьж дуусаагүй, гэрээний үүргээ биелүүлээгүй, Үнсэн сангийн зураг, төсөв гүйцэтгүүлэх ажлын гүйцэтгэл дуусаагүй, гэрээ дүгнээгүй, төлөвлөгөөнөөс хэтрүүлэн 50.2 сая төгрөгийг илүү шилжүүлж худалдан авалтыг холбогдох хууль, журмын дагуу хийгээгүй, Зорилтот түвшингийн нийт зардал 620.8 сая төгрөгөөр хэтэрсэн зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн "Үнэн зөв байдал, Эрх ба үүрэг, Хэмжилт" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага


"Дулааны цахилгаан станц-3" ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай, нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

B. M.

Ц.НАРАНЧИМЭГ



2 Аудитын тайлан

2.1. Оршил

"Дулааны цахилгаан станц-3" ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг "Дулааны цахилгаан станц-3" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Чинбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Дулааны цахилгаан станц-3" ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

"Дулааны цахилгаан станц-3" ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

"Дулааны цахилгаан станц-3" ТӨХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 03 дугаар сарын 04-ний өдрөөс 2019 оны 03 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Л.Хонгорзул, аудитор Б.Даваабаатар нар хариуцаж хэрэгжүүлэв.

"Дулааны цахилгаан станц-3" ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 1/442 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

"Дулааны цахилгаан станц-3" ТӨХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

"Эх орноо хөгжилд хөтлөх эрчим хүчийг бүтээнэ" уриаг эрхэм болгож цахилгаан ба дулаан үйлдвэрлэх, дулаан түгээх, цахилгаанаар зохицуулалттай хангах, дулааны зохицуулалттай хангаж ажиллана гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

"Дулааны цахилгаан станц-3" ТӨХК-ийн Эрчим хүчний сайдын өгсөн үүрэг даалгавар, тушаал, шийдвэрт нийцүүлэн тушаал гаргаж, биелэлтийг хангах, үйл ажиллагааны дараах тэргүүлэх чиглэл нь:

Компанийн өөрчлөлт, хөгжлийн стратегитай уялдсан хүний нөөцийн удирдлагын цогц арга барилыг хэрэгжүүлэх, ажилчдын ажиллах эрүүл аюулгүй, таатай нөхцлийг бүрдүүлэх, нийгмийн баталгааг хангах, тэднийг сургаж хөгжүүлэх, ажлын үр дүнг үнэлж санал

санаачилгыг дэмжиж ажиллах, хүний нөөцийн удирдлагын манлайллыг бий болгож, дотоод хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах, мэдээллийн дэвшилтэт технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллах, гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, гадаадын санхүүжилттэй хөтөлбөр, төслийн харилцаа холбоог тогтоож хамтарч ажиллах, мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулах, хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд чиглэсэн аливаа эрх зүйн үндэслэлтэй шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахад дэмжлэг үзүүлж, шаардлагатай мэдээлэл зөвлөгөө, дэмжлэгээр хангах, хяналт тавьж ажиллах, ажлын хариуцлага сахилга батыг сахиулах, олон нийттэй харилцах, урлаг соёлын үйлчилгээ үзүүлэх, Захиргаа, соёлын төв, лабораторийн байрны нийтийн эзэмшлийн хэсэг болон эд аж ахуйн бүрэн бүтэн, гал усны аюулгүй байдлыг хангах, тохижилт, соёлжилтыг сайжруулж цэвэр цэмцгэр орчин бүрдүүлэх үндсэн чиг үүрэгтэй ажиллаж байна.

"Дулааны цахилгаан станц-3" ТӨХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

"Дулааны цахилгаан станц-3" ТӨХК-ийн удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль
- Эрчим хүчний тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Завсарын аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу мөнгөн кассын мөрдөх журмыг шинэчлэн баталсан, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлтүүд оруулсан, хөдөлмөрийн дотоод журмын заалтуудыг нэмэлт өөрчлөлт оруулах явцын ажлын хийгдсэн.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

"Дулааны цахилгаан станц-3" ТӨХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

"Дулааны цахилгаан станц-3" ТӨХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

"Дулааны цахилгаан станц-3" ТӨХК-ийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Юникус" програм хангамж ашигладаг байна.

"Дулааны цахилгаан станц-3" ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "Бага" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад "Дулааны цахилгаан станц-3" ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 15 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардлыг сонгов.

Энэ нь Мөнгөн гүйлгээний зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь нийт хөрөнгийн дүнгээс тооцоход их байгаатай холбоотой юм.

"Дулааны цахилгаан станц-3" ТӨХК-ийн 2018 оны мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардал 97,102.8 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 971.0 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь нийт хөрөнгийн дүнгээс тооцвол их дүн гарч байгаатай холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг В201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 17 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 11 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 2 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэн.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	1,129.8	
2	Төлбөрийн акт	1	9.6	
3	Албан шаардлага өгсөн	3	3,475.7	
	Дүн	7	4,615.1	

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Асуудал 1: Журам, баримт бичгийн талаар

Аудитын явцад мөнгөн кассын үйл ажиллагааны журамд сарын татан авалтын мөнгөн дүнгийн хязгаарыг заагаагүй, байгууллагын дотоод журамд буцалтгүй тусламжийн хэмжээ хязгаарыг тогтоогоогүй, НБББББ-ийн 4.2-т Авлагын бүртгэлийн талаар тусгасан боловч

Авлагын насжилт, түүний хувь, аргачлал, найдваргүй авлагын нөөц байгуулах зэрэг заалтуудыг оруулаагүй байсныг залрууллаа.

Шийдэл: Журам болон баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулсан

Асуудал 2: Зардлын талаар

1. Сургалт, шагнал урамшуулал, байгууллагын 50 жилийн ойн баяр, эмчилгээ, нийт 538.3 сая төгрөгийн зардлыг "Борлуулсан бүтээгдэхүүний өртөг" дансанд бүртгэсэн байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 20.2.4-д "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", НБББББ-ийн 4.9.4-д "Үйлдвэрлэлийн зардал:Цахилгаан, дулаан, уур, гүний худгийн ус, хийн аж ахуйн гэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтэй шууд ба шууд бус холбоотой гарах бүхий л зардлууд орно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдэл: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудыг баримтлан хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага өгөв.

2. Харьяа дээд байгууллага буюу Эрчим хүчний яамны удирдах албан тушаалтнуудын гадаад томилолтын зардалд 9.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2018 оны А-1/350 дугаар Албан даалгаврын 3-т "...төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс дээд шатны байгууллага яам, төрийн захиргааны байгууллагын зардлыг санхүүжүүлэх (суудлын автомашины зардал, томилолтын зардал, сургалт сурталчилгааны зардал болон бусад арга хэмжээний зардал г.м)"-ийг таслан зогсоох, зөрчсөн албан тушаалтанд хуулийн хүрээнд хариуцлага тооцож, хохирлыг нөхөн төлүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдэл: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоолын холбогдох заалтуудыг баримтлан хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага өгөв.

3. ТУЗ-ийн 2014 оны 23 дугаар тогтоол, шийдвэрээр Ажилчдын орон сууц бариулах ажлын хэсэг 3 компаниас үнийн санал авч "Соёмбо констракшн" ХХК-тай 2015 оны 2-270/15 дугаар гэрээ хийж, 735 ажилчдын 7 орон сууцны барилгыг 2017 онд багтаан дуусгах байсан боловч өнөөг хүртэл ашиглалтанд оруулаагүй, хүлээлгэж өгөөгүй байна. "ДЦС-3" ТӨХК орон сууцны дэмжлэг үзүүлэх зардалд 210 ажилтанд 1,546.2 сая төгрөг, 74 ажилчид захиалгын гэрээ хийж урьдчилгаа төлбөрт 871.8 сая төгрөг, нийт 2,418.0 сая төгрөгийг төлсөн байна.

Энэ нь гэрээний 6.2-д "Захилагч болон гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй бол хугацаа хэтрүүлсэн тал нь тухайн гүйцэтгээгүй үүргийн дүнгийн 0.05 хувиас хэтрэхгүй хэмжээгээр буруутай талдаа алданги ногдуулна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдэл: ТУЗ-ийн тогтоол, шийдвэр, орон сууцны барилга барих гэрээний холбогдох заалтуудыг баримтлан хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага өгөв.

Асуудал 3: Авлага, өглөгийн талаар

Тайлант онд авлага 5,524.1 сая, өглөг 2,049.7 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс байгууллага аж ахуйн нэгжтэй холбоотой 230.3 сая төгрөгийн авлага, 114.1 сая төгрөгийн өглөг, нийт 344.5 сая төгрөгийн авлага, өглөгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй, тооцоо нийлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", НБББББ-ийн 4.2 дугаар бүлгийн 7-д "Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 171/111 тоот тушаалаар баталсан Тооцооны үлдэгдлийн баталгаа /НХМаягт-3/ маягт эсвэл ажил үйлчилгээний онцлогт тохирсон маягтын үндсэн дээр харилцагч байгууллагуудтай тооцооны үлдэгдлийг улирал, жилийн эцэст тулган тохируулж тооцоо нийлсэн актыг үйлдэнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдэл: Нягтлан бодох бүртгэлийн хууль, байгууллагын бодлогын баримт бичгийн холбогдох заалтуудыг баримтлан хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага өгөв.

Асуудал 4: Худалдан авалтын талаар

1. Байгууллагын 50 жилийн ойн баярт зориулсан худалдан авалт хийхдээ нээлттэй сонгон шалгаруулалт хийгээгүй 6 байгууллагатай харьцуулалтын аргаар 182.4 сая төгрөг, 6 байгууллагатай шууд гэрээ хийж 124.7 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6.1-д "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 12.1-д "Тендерт оролцогчдыг тэгш боломжоор хангаж, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тендер шалгаруулалтад оролцохыг сонирхсон этгээдүүдийн ерөнхий, санхүүгийн, техникийн чадавхи болон туршлагыг энэ хуулийн 14-16 дугаар зүйлд заасан үзүүлэлтээр хянан үзэж магадлана" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдэл: Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтуудыг баримтлан хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага өгөв.

2. Үнсэн сангийн зураг, төсөв гүйцэтгүүлэхээр "Усны эрчим" ХХК-тай 2018 оны 3 дугаар сарын 26-ны өдөр 63/19 дүгээр гэрээ байгуулж, санхүүжилтийн урьдчилгаа 30 хувь, ажил дуусч хүлээн авсны дараа 70 хувийг шилжүүлэх байсан боловч ажлын гүйцэтгэл дуусаагүй, гэрээ дүгнээгүй байхад 43.0 сая төгрөгийг илүү шилжүүлсэн, Мазутыг 840.0 сая төгрөгөөр авахаар төлөвлөсөн боловч 847.2 сая төгрөгөөр худалдан авалт хийж, төлөвлөгөөнөөс 7.2 сая төгрөг илүү зарцуулсан байна.

Энэ нь ТБОНӨБАУХАТ хуулийн 46.1.4-д "Худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж зохион байгуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдэл: Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтуудыг баримтлан хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага өгөв.

3. Гүйцэтгэх захирлын 2018 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн А/65 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хорооны гишүүд Шүүх материал КУ-2 худалдан авах тендерийн сонгон шалгаруулалтыг зөв үнэлээгүй, Гүйцэтгэх захирлын 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн А/135 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хорооны гишүүд мөнгөн тооцоо хийдэг ухаалаг тоолуур худалдан авах тендерийн сонгон шалгаруулалтыг зөв үнэлээгүйгээс тус тус гомдол гарсан байна.

Энэ нь ТБОНӨБАУХАТ хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.2-д "Тендерийг хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийг захиалагчид өгөх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдэл: Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтуудыг баримтлан хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага өгөв.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Хөрөнгийн дахин үнэлгээг "Хүлэгтхүннү аудит" ХХК-ийн үнэлгээчин санхүүгийн тайлагналын бодит үнэ цэнийг 113,503.9 сая төгрөг гэж тооцоолж, компанийн газар эмэмших эрх, барилга, байгууламжийн нийт хөрөнгийг үнэлж, дүгнэлт өгсөн боловч тоног төхөөрөмжийн шинж чанар, ангилалаас хамаарч барилга байгууламж руу шилжүүлэх болон шилжсэн хөрөнгийг дараагийн аудитад хамруулан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төрийн өмчит хувьцаат компани нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

"Дулааны цахилгаан станц-3" ТӨХК чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор ТӨБЗГ-ын 2017 оны 660 дугаар тогтоолоор тус компанийн 2018 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшингийн төлөвлөгөөг 113,121.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлэх, 112,962.1 сая төгрөгийн зардал зарцуулах, 20,989.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэхээр батлагдсан байхад нийт зардал 620.8 сая төгрөгөөр хэтэрсэн байна. Тухайлбал: ажилчдын нийгмийн асуудлын зардалд 101.5 сая, галын аюулын зардал 20.8 сая, удирдлагын зардал 21.4 сая, шатахууны зардал 25.9 сая, түлшний зарцуулалт 196.0 сая, цахилгааны зардал 293.2 сая, урсгал засвар 146.1 сая, хөдөлмөр хамгаалалын зардлыг 26.1 сая төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулжээ.

2.11. Шилэн дансны мэдээлэл

“Дулааны цахилгаан станц-3” ТӨХК Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

“Дулааны цахилгаан станц-3” ТӨХК Шилэн дансны тухай хуулийн дагуу тус байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн shilendans.gov.mn/Дулааны цахилгаан станц 3 ТӨХК цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар 2018 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлангийн талаар 445, хөрөнгийн урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийн талаар 228, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн талаар 569, нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийн талаар 912, нийт 2154 мэдээллийг боловсруулан хуулийн хугацаанд байршуулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 5 зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Дулааны цахилгаан станц-3” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Дулааны цахилгаан станц-3” ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь "Дулааны цахилгаан станц-3" ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. "Зардлын данстай холбоотой асуудал"

3.1.1. Илрүүлэлт

Компанийн 50 жилийн ойн баярын арга хэмжээний зардлын төсвийг ТУЗ-ийн 2018 оны 12 тоот тогтоолоор 524.0 сая төгрөг, ажиллагсдыг урамшуулах төсвийг 2018 оны 17 дугаар тогтоолоор 509.0 сая төгрөг, нийт 1,033.0 сая төгрөгөөр батлуулсан байна. Шагнал урамшуулалд 1018 ажилтанд 0.5 сая төгрөгөөр тооцон 509.0 сая төгрөгийг олгосон ба 1 ажилтанд ногдох мөнгөн дүнгийн тооцоололгүй, шалгуур үзүүлэлтгүй, үндэслэлгүй хавтгайруулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх хэрэгтэй", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 6.4.2-д "Төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

3.1.2. Эрсдэл

Төсвийн хөрөнгө зориулалт бусаар зарцуулагдах

3.1.3. Өгсөн зөвлөмж

Дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

3.2. "Орлогын данстай холбоотой асуудал"

3.2.1. Илрүүлэлт

ТӨБЗГ-ын 2017 оны 53 дугаар тогтоолын 1.2-д "Төрийн өмчийн талбай болон бусад эд хөрөнгийг түрээслэхэд түрээслүүлэгч хуулийн этгээдийн удирдлагын тушаалаар комисс байгуулна" гэсэн заалтын дагуу сонгон шалгаруулсан байна. ТӨБЗГ-ын 2017 оны А-5/1859 дүгээр албан бичгээр түрээсийн гэрээг 2017 оны 8 дугаар сарын 20-ны дотор баталгаажуулах гэсэн мэдэгдлийн дагуу гэрээг хүргүүлсэн боловч өнөөг хүртэл ТӨБЗГ гэрээг баталгаажуулаагүй байна.

3.2.2. Эрсдэл

Түрээсийн орлого бүрэн төлөвлөрүүлэхгүй байх

3.2.3. Өгсөн зөвлөмж

Дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын холбогдох тогтоол, шийдвэрийн дагуу түрээсийн гэрээ байгуулан ажиллах талаар зөвлөмж өгөв.

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

3.3. "Зорилтот түвшингийн хэрэгжилттэй холбоотой асуудал"

3.3.1. Илрүүлэлт

"Дулааны цахилгаан станц-3" ТӨХК чиг үүргээ хэрэгжүүлэхтэй ТӨБЗГ-ын 2017 оны 660 дугаар тогтоолоор тус компанийн 2018 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшингийн төлөвлөгөөг 113,121.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлэх, 112,962.1 сая төгрөгийн зардал зарцуулах, 20,989.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэхээр батлагдсан байхад нийт зардлыг 620.8 сая төгрөгөөр хэтэрсэн байна. Тухайлбал: ажилчдын нийгмийн зардал 101.5 сая, галын аюулын зардал 20.8 сая, удирдлагын зардал 21.4 сая, шатахууны зардал 25.9 сая, түлшний зарцуулалт 196.0 сая, цахилгааны зардал 293.2 сая, урсгал засвар 146.1 сая, хөдөлмөр хамгаалалын зардлыг 26.1 сая төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулжээ.

3.3.2. Эрсдэл

Батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулах, хуулиар хүлээсэн үүргийг биелүүлэхгүй байх

3.3.3. Өгсөн зөвлөмж

Дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, Зорилтот түвшингийн хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт тавин ажиллах талаар зөвлөмж өгөв.

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	5,202,558,660.64	1,861,515,381.22
1.1.2	Дансны авлага	2,744,921,303.42	8,269,057,413.46
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	504,311,298.00	18,723,902.88
1.1.4	Бусад авлага	28,496,416.62	85,293,414.29
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	8,986,050,490.38	10,263,530,840.62
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	800,922,815.61	353,621,543.70
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	18,267,260,984.67	20,851,742,496.17
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	188,565,431,131.19	196,317,730,986.38
1.2.2	Биет бус хөрөнгө	524,593,012.10	39,119,302,865.49
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	204,765,158.10	204,765,158.10
1.2.9	Дуусаагүй барилга		78,834,409.45
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	189,294,789,301.39	235,720,633,419.42
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	207,562,050,286.06	256,572,375,915.59
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	1,916,321,196.23	3,029,887,605.26
2.1.1.2	Цалингийн өглөг		2,908,371,054.00
2.1.1.3	Татварын өр		279,297,423.23
2.1.1.4	НДШ-ийн өглөг		

"Дулааны цахилгаан станц-3" ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

2.1.1.5	Богино хугацаат зээл	1,934,911,109.12	1,938,135,162.16
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	5,132,187.56	3,149,649.12
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	174,695,430.50	76,053,516.78
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	4,031,059,923.41	8,234,894,410.55
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	21,844,404,065.48	19,958,283,667.98
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	1,616,657,358.28	1,616,657,358.28
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	2,627,103,921.00	2,359,088,948.13
2.1.2.5			
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	26,088,165,344.76	23,934,029,974.39
2.2	Өр төлбөрийн нийт дүн	30,119,225,268.17	32,168,924,384.94
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	99,362,782,973.56	138,057,432,973.56
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	100,760,943,463.55	109,828,620,258.29
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-22,680,901,419.22	-23,482,601,701.20
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	177,442,825,017.89	224,403,451,530.65
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	207,562,050,286.06	256,572,375,915.59

4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	110,679,297,492.49	112,093,663,730.65
2	Борлуулалтын өртөг	100,002,473,952.09	103,818,953,637.00
3	Нийт ашиг(алдагдал)	10,676,823,540.40	8,274,710,093.65
4	Түрээсийн орлого	57,655,682.78	57,056,024.21
5	Хүүгийн орлого	535,344,405.06	425,810,812.99
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	938,694,939.25	1,436,280,268.34
9	Борлуулалт, маркетингийн зардал		247,336,004.60
10	Ерөнхий ба удирдлагын зардал	7,228,740,598.47	6,925,447,884.52
11	Санхүүгийн зардал	461,213,982.14	427,051,186.58
12	Бусад зардал	997,126,274.05	3,687,470,588.43
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-5,981,561.26	17,500,235.48
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-1,395,803,570.37	37,041,622.52
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	2,119,652,581.20	-1,038,906,606.94
19	Орлогын татварын зардал	1,670,191,798.80	42,581,081.30
20	Татварын дараах ашиг (алдагдал)	449,460,782.40	-1,081,487,688.24
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	449,460,782.40	-1,081,487,688.24
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2017 оны 12 -р сарын 31- ний үлдэгдэл	99,362,782,973.56	100,760,943,463.55		-22,680,901,419.22	177,442,825,017.89
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
Залруулсан үлдэгдэл	99,362,782,973.56	100,760,943,463.55		-22,680,901,419.22	177,442,825,017.89
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				-1,081,487,688.23	-1,081,487,688.23
Бусад дэлгэрэнгүй орлого					
Өмчид гарсан өөрчлөлт	38,694,650,000.00				38,694,650,000.00
Зарласан ногдол ашиг				44,946,080.00	44,946,080.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		9,067,676,794.74		324,733,486.26	9,392,410,281.00
2018 оны 12 -р сарын 31 - ний үлдэгдэл	138,057,432,973.56	109,828,620,258.29		-23,482,601,701.19	224,403,451,530.66

4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлайт он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	111,023,655,565.41	106,305,272,522.88
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	109,885,815,420.82	105,014,938,618.24
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	225,233,640.16	223,546,892.00
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	912,606,504.43	1,066,787,012.64
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	92,782,051,444.89	97,102,872,670.02
1.2.1	Ажиллагчдад төлсөн	24,192,939,319.59	19,924,865,045.02
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	6,131,600,000.00	5,981,000,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	43,464,574,440.00	50,380,775,700.10
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	1,836,435,331.77	1,837,015,276.89
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	7,767,242,088.27	9,595,666,542.16
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	73,663,323.69	63,472,729.18
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	7,330,696,894.81	7,012,917,715.63
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	119,331,949.00	112,512,622.20
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,865,568,097.76	2,194,647,038.84
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	18,241,604,120.52	9,202,399,852.86
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	535,344,405.06	425,810,812.99
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого		
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	535,344,405.06	425,810,812.99
2.1.8			

"Дулааны цахилгаан станц-3" ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	15,613,131,411.09	12,767,422,998.06
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	15,493,083,320.09	12,738,840,498.06
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	120,048,091.00	28,582,500.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.2.6			
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-15,077,787,006.03	-12,341,612,185.07
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4			
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	122,379,605.88	201,830,947.21
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	122,379,605.88	201,830,947.21
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		
3.2.5			
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-122,379,605.88	-201,830,947.21
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	3,041,437,508.61	-3,341,043,279.42
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,202,558,660.64	5,202,558,660.64
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,202,558,660.64	1,861,515,381.22

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн биелэлт

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 оны гүйцэтгэл	2018 он		Биелэлт	
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
A	Б	В	1	2	3	4=3/2*100	5=3-2
1	Үйлдвэрлэсэн ЦЭХ	сая.квтц	1,077.7	1,036.5	1,085.0	104.7	48.6
		хувь	16.31	16.90	16.54	97.9	-0.36
		сая.квтц	175.8	175.2	179.5	102.5	4.3
	ЦЭХ	сая.квтц	901.9	861.3	905.5	105.1	44.3
	ДЭХ	мян.Гкал	2,163.0	2,279.1	2,192.7	96.2	-86.4
	Нийт орлого	сая.төг	112,222.5	113,121.1	114,115.1	100.9	993.9
	Үүнээс: Борлуулалтын орлого	сая.төг	110,679.3	111,955.8	112,093.7	100.1	137.8
	Үйл ажиллагааны бус орлого	сая.төг	1,543.2	1,165.3	2,021.4	173.5	856.1
	Нийт зардал	сая.төг	110,102.8	112,962.1	115,154.0	101.9	2,191.9
	Үүнээс: Удирдлагын	сая.төг	277.9	281.4	302.9	107.6	21.5
	Үйл ажиллагааны зардал	сая.төг	107,414.5	111,099.0	111,698.3	100.5	599.3
6	Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал -/	сая.төг	2,119.7	159.1	-1,038.9	-653.1	1,198.0
7	Цэвэр ашиг /алдагдал-/	сая.төг	449.5	143.2	-1,038.9	-725.5	1,182.1
8	Төрийн өмчийн ноогдол ашиг	сая.төг	70.4	43.0	0.0	0.0	-43.0
9	Борлуулалтын орлогын 1 төг-т ногдох зардал	төг	0.98	1.00	1.01	101.1	0.01
10	Нийт авлага	сая.төг	3,277.7	3,852.8	8,373.1	217.3	4,520.3
	Нийт өглөг	сая.төг	30,119.2	27,979.5	32,168.9	115.0	4,189.4
	Үүнээс: Богино хугацаат	сая.төг	4,031.1	8,020.5	8,234.9	102.7	214.4
12	Хөрөнгө оруулалт, их засвар ТЗБАХэмжээ	сая.төг	18,176.8	20,989.6	18,119.0	86.3	2,870.5
13	Нийт ажиллагсадын тоо	тоо	996	996	993	100	-3
14	Нийт цалингийн сан	сая.төг	25,712.4	25,937.7	25,966.9	100.1	29.2

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2018 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:	САГ-2019/109/СТА-ТӨХК
Шалгагдсан байгууллагын нэр:		"Дулааны цахилгаан станц-3" ТӨХК		Сая төгрөгөөр	
A	3	4	байгууллагаас гаргасан шийдэл Нэр	Алдаа зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтан	Овог нэр
1			5	8	9
1	Аудитын явцад мөнгөн кассын үйл ажиллагааны журамд сарын татан авалтын мөнгөн дүнгийн хязгаарыг заагаагүй, байгууллагын дотоод журамд буцалтгүй тусламжийн хэмжээ хязгаарыг тогтоогоогүй, НБББББ-ийн 4.2-т Авлагын бүртгэлийн талаар тусгасан боловч Авлагын насжилт, түүний хувь, аргачлал, найдваргүй авлагын нөөц байгуулах зэрэг заалтуудыг оруулаагүй байсныг залрууллаа.		Залруулсан	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч	Ч.Чинбат Ч.Чулуунчимэг
2	Шагнал урамшуулалд 1018 ажилтанд 0.5 сая төгрөгөөр тооцон 509.0 сая төгрөгийг олгосон ба 1 ажилтанд ногдох мөнгөн дүнгийн тооцоололгүй, шалгуур үзүүлэлттгүй, үндэслэлгүй хавтгайруулан олгосон байна.	509.0	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Ч.Чинбат Ч.Чулуунчимэг
3	Сургалт, шагнал урамшуулал, байгууллагын 50 жилийн ойн баяр, эмчилгээ, нийт 538.3 сая төгрөгийн зардлыг "Борлуулсан бүтээгдэхүүний өртөг" дансанд ангилала буруу бүртгэсэн байна	538.3	Албан шаардлага өгөх	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Ч.Чинбат Ч.Чулуунчимэг
4	Харьяа дээд байгууллага буюу Эрчим хүчний яамны удирдах албан тушаалтнуудын гадаад томилолтын зардалд 9.6 сая төгрөгийг зарцуулсан	9.6	Төлбөрийн акт тавих	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Ч.Чинбат Ч.Чулуунчимэг
5	ТУЗ-ийн 2014 оны 23 дугаар тогтоол, шийдвэрээр Ажилчдын орон сууц бариулах ажлын хэсэг 3 компаниас үнийн санал авч "Соёмбо констракшн" ХХК-тай 2015 оны 2-270/15 тоот гэрээ хийж, 735 ажилчдын 7 орон сууцны барилгыг 2017 онд багтаан дуусгах байсан боловч өнөөг хүртэл ашиглалтанд оруулаагүй, хүлээлгэж өгөөгүй байна. "ДЦС-3" ТӨХК орон сууцны дэмжлэг үзүүлэх зардалд 210 ажилтанд 1,546.2 сая төгрөг, 74 ажилчид захиалгын гэрээ хийж урьдчилгаа төлбөрт 871.8 сая төгрөг, нийт 2,418.0 сая төгрөгийг төлсөн байна.	2,418.0	Албан шаардлага өгөх	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Ч.Чинбат Ч.Чулуунчимэг

"Дулааны цахилгаан станц-3" ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

6	Байгууллага аж ахуйн нэгжтэй холбоотой 230.3 сая төгрөгийн авлага, 114.1 сая төгрөгийн өглөг, нийт 344.5 сая төгрөгийн авлага, өглөгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй, тооцоо нийлээгүй байна	344.5	Албан шаардлага өгөх	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Ч.Чинбат Ч.Чулуунчимэг
7	ТӨБЗГ-ын 2017 оны 53 дугаар тогтоолын 1.2-д "Төрийн өмчийн талбай болон бусад эд хөрөнгийг түрээслэхэд түрээслүүлэгч хуулийн этгээдийн удирдлагын тушаалаар комисс байгуулна" гэсэн заалтын дагуу "Билиг арвижих" ХХК-ийг сонгон шалгаруулсан байна. ТӨБЗГ-ын 2017 оны А-5/1859 дүгээр албан бичгээр түрээсийн гэрээг 2017 оны 8 дугаар сарын 20-ны дотор баталгаажуулах гэсэн мэдэгдлийн дагуу гэрээг хүргүүлсэн боловч өнөөг хүртэл ТӨБЗГ гэрээг баталгаажуулаагүй байна.		Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Ч.Чинбат Ч.Чулуунчимэг
8	Байгууллагын 50 жилийн ойн баярт зориулсан худалдан авалт хийхдээ нээлттэй сонгон шалгаруулалт хийгээгүй 6 байгууллагатай харьцуулалтын аргаар 182.4 сая төгрөг, 6 байгууллагатай шууд гэрээ хийж 124.7 сая төгрөгийн тус тус зарцуулсан байна	124.7	Албан шаардлага өгөх	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Ч.Чинбат Ч.Чулуунчимэг
9	Үнсэн сангийн зураг, төсөв гүйцэтгүүлэхээр "Усны эрчим" ХХК-тай 2018 оны 3 дугаар сарын 26-ны өдөр 63/19 дүгээр гэрээ байгуулж, санхүүжилтийн урьдчилгаа 30 хувь, ажил дуусч хүлээн авсаны дараа 70 хувийг шилжүүлэх байсан боловч ажлын гүйцэтгэл дуусаагүй, гэрээ дүгнээгүй байхад 43.0 сая төгрөгийг илүү шилжүүлсэн, Мазутыг 840.0 сая төгрөгөөр авахаар төлөвлөсөн боловч 847.2 сая төгрөгөөр худалдан авалт хийж, төлөвлөгөөнөөс 7.2 сая төгрөг илүү зарцуулсан байна.	50.2	Албан шаардлага өгөх	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Ч.Чинбат Ч.Чулуунчимэг
10	Гүйцэтгэх захирлын 2018 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн А/65 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хорооны гишүүд Шүүх материал КУ-2 худалдан авах тендерийн сонгон шалгаруулалтыг зөв үнэлээгүйгээс гомдол гарсан, Гүйцэтгэх захирлын 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн А/135 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хорооны гишүүд мөнгөн тооцоо хийдэг ухаалаг тоолуур худалдан авах тендерийн сонгон шалгаруулалтыг зөв үнэлээгүй байна		Албан шаардлага өгөх	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Ч.Чинбат Ч.Чулуунчимэг
11	ТӨБЗГ-ын 2017 оны 660 дугаар тогтоолоор тус компанийн 2018 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшин, төлөвлөгөөг 113,121.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлэх, 112,962.1 сая төгрөгийн зардал гаргах, 20,989.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэхээр батлагдсан байна. Зорилтот түвшингийн нийт зардал 2,191.8 сая төгрөгөөр хэтэрсэн нь байна. Тухайлбал: ажилчдын нийгмийн зардал 101.5 сая, галын аюулын зардал 20.8 сая, удирдлагын зардал 21.4 сая, шатахууны зардал 25.9 сая, түлшний зарцуулалт 196.0 сая, цахилгааны зардал 293.2 сая, урсгал засвар 146.1 сая, хөдөлмөр хамгаалалын зардлыг 26.1 сая төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулжээ.	620.8	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Ч.Чинбат Ч.Чулуунчимэг
Нийт дүн		4,615.1			